КЕСАР МЭС ЗАСЛЫН ДАРААХ ШАРХНЫ ХАЛДВАР ҮҮСЭХЭД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ СУДАЛСАН НЬ

*Б.Туул[1] Ч.Цагаанхүү [1] Б.Туяа[1] , С.Түмэнжаргал[1],С.Даваасүрэн[1], О.Баатархүү[2], Б.Жаргалсайхан[2]**

[*]Хариуцлагатай зохиогч, емайл хаяг: jargalsaikhan.b@mnums.edu.mn
[1]Нийслэлийн Хүрээ Амаржих Газар,
[2]Анагаах Ухааны Сургууль, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

Түлхүүр үг:
Нийслэлийн Хүрээ амаржих Газар, Кесар мэс засал, шархны халдвар, таргалалт, тамхи таталт

Товч утга: Олон улсын хэмжээнд анхан болон давтан кесар мэс заслын давтамж сүүлийн хорин жилийн хугацаанд эрс нэмэгдэж, 2015 онд нийт амьд төрөлтөнд кесар мэс засал нь 21% (140.6 сая төрөлтийн 29.7 сая нь кесар мэс заслаар төрсөн) -ийг эзэлсэн байна. Дэлхий дахинд кесар мэс заслын дараах шархны халдвар 3-15%ийг эзэлж байна. Кесар мэс заслын дараах шархны халдварын тохиолдол хүн ам зүйн ялгаатай байдал, эрсдэлт хүчин зүйлс, мэс заслын өмнөх бэлтгэл, хагалгааны үргэлжлэх хугацаа зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан үүснэ.

Арга, аргачлал : Нийслэлийн Хүрээ амаржих газрын өчний түүхэнд эргэн лавламж судалгааны аргаар судалгаа хийсэн.

Судалгааны үр дүн: Кесар мэс заслын дараах шархны халдвараар өвчилсөн эмэгтэйчүүдийг насны ангиллаар судлахад 25-35 насны эмэгтэйчүүд хоёр хүн тутмын нэг буюу 54%-ийг эзэлж байснаас 60% нь эхийн болон ургийн дистресс хам шинжийн заалтаар анх удаа кесар хагалгаанд орсон байв. Кесар хагалгааны дараах халдварлагдсан шархтай 45 эхийн мэс заслын шархнаас эмгэг төрөгч илрүүлэх арчдасын шинжилгээ авахад 11,1%-д эмгэг төрөгч илэрсэн, илрээгүй 15,5 % байсан. Халдварлагдсан шархтай 45 эхчүүдийн нийт ор хоног 32, боолт давхардсан тоогоор 1554 удаа, шарлага 796 удаа /199 цаг/, нийт хэрэглэсэн эмийн зардалд 24,473946 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Дүгнэлт : НХАГ-т 2018-2019 он, 2020 оны хагас жилийн байдлаар нийт 1823 эх кесар мэс засал хийлгэснээс халдварлагдсан шархтай 45 эх /2,46%/ мэс заслын дараах тусламж үйлчилгээ авсан байна. Эрүүл мэндийн байгууллагын зүгээс нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бага, эерэг дүнтэй байна. Кесар хагалгааны дараах шархны халдвар эмчлэхэд ор хоног 32, эмчилгээний зардалд 24,473946 төгрөг зарцуулж байгаа нь эмч, сувилагчдын ажлын ачаалал нэмэгдэж, байгууллагын эмийн зардалд нөлөөлж байна.

Үндэслэл: Олон улсын хэмжээнд анхан болон давтан кесар мэс заслын давтамж сүүлийн хорин жилийн хугацаанд эрс нэмэгдсээр байна. Тухайлбал, кесар мэс заслын давтамж жил бүр 3.7%-иар нэмэгдэн, 2000 онд 131.9 сая төрөлтийн 16 сая нь кесар мэс заслаар төрж нийт амьд төрөлтийн 16% ийг эзэлж байсан бол 2015 онд нийт амьд төрөлтөнд кесар мэс засал нь 21% (140.6 сая төрөлтийн 29.7 сая нь кесар мэс заслаар төрсөн) -ийг эзэлсэн байна.[1-3] Кесар мэс заслын дараах хүндрэлүүд, ялангуяа шархны халдварын улмаас эх олон хоног эмнэлэгт хэвтэн, эмнэлгийн тусламж үйлчилгээний өртөг нэмэгдэж, нийгэм эдийн засгийн хүндрэл үүсч, эхийн амьдралын чанарт нөлөөлдгийг олон тооны судалгаанууд баталсан байна.

Дэлхий дахинд кесар мэс заслын дараах шархны халдвар 3-15%ийг эзэлж байна. Кесар мэс заслын дараах шархны халдварын тохиолдол хүн ам зүйн ялгаатай байдал, эрсдэлт хүчин зүйлс, мэс заслын өмнөх бэлтгэл, хагалгааны үргэлжлэх хугацаа зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалан үүснэ.[4-6]

Сүүлийн гучин жилийн хугацаанд кесар мэс засалд антибиотикийн урьдчилсан сэргийлэлт нэвтэрсэн, эрүүл ахуйн дэглэм болон мэс заслын багажийн ариун байдал сайжирсантай холбоотой мэс заслын дараах шархны халдварын хүндрэл буурсаар байна.[7-8] Гэсэн хэдий ч кесар хагалгааны давтамж нэмэгдэж байгаатай уялдан мэс заслын дараах шархны халдвар нэмэгдэх эрсдэл хүлээгдэж байна.[9].

Нийслэлийн Хүрээ Амаржих Газарт кесар мэс заслын дараах шархны халдварын байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг судалж, цаашид халдварлагдсан шархны тоог цөөрүүлэх, мэс заслын өмнөх ба дараах сувилахуйн тусламжийн чанарыг өндөр түвшинд чанартай үзүүлэх шаардлага тулгарч байна.

Зорилго: Нийслэлийн Хүрээ Амаржих Газарт яаралтай болон төлөвлөгөөт журмаар кесар мэс засалд орсон эмэгтэйчүүдийн шархны халдварт үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг судлах

Зорилт:

1. Нийслэлийн "Хүрээ" Амаржих Газарт 2018, 2019 он, 2020 оны эхний хагас жилд яаралтай болон төлөвлөгөөт журмаар кесар мэс засал хийлгэсэн эмэгтэйчүүдийн шархны халдвар үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйлсийг тогтоох
2. Кесар хагалгааны дараа халдварлагдсан шархтай эмэгтэйчүүд төрөх эмнэлэгт эргэн хэвтэх нь байгууллага, эмнэлгийн мэргэжилтний ажлын ачаалалд хэрхэн нөлөөлөхийг судлах

Судалгааны арга зүй: Нийслэлийн Хүрээ Амаржих Газрын төрөх тасагт 2018, 2019 он, 2020 оны эхний 6 сарын байдлаар 1823 жирэмсэн эмэгтэйчүүд эх барихын хүндрэл, ургийн дистресс хам шинжийн заалтаар кесар мэс засал хийлгэсэн байна. Эдгээр эмэгтэйчүүдээс 45 эх "Кесар мэс заслын дараах шархны халдвар" оношоор Хүрээ амаржих газарт төрсний дараах 15-30 дахь хоногт эргэн ирж хэвтсэн. Өвчний түүхэнд эргэн лавламж судалгааны аргаар судалгаа хийсэн. Судалгааны асуумж боловсруулан, эргэн түүвэрлэлт, бүртгэлийн аргаар тоон мэдээлэлд боловсруулалтыг Excel программыг ашиглан гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүн: Кесар мэс заслын дараах шархны халдвараар өвчилсөн эмэгтэйчүүдийг насны ангиллаар судлахад 25-35 насны эмэгтэйчүүд хоёр хүн тутмын нэг буюу 54%-ийг эзэлж байснаас 60% нь эхийн болон ургийн дистресс хам шинжийн заалтаар анх удаа кесар хагалганд орсон байв. НХАГ-т кесар хагалгааны дараа шархны халдвар авсан эмэгтэйчүүдийн 60% нь төрснөөс хойш 15-30 хоногийн дараа эмнэлэгт эргэн хандсан байна. Кесар мэс заслаар төрсөн эмэгтэйчүүдийг биеийн жингээр судлахад 85-100кг жинтэй эхчүүд 40%, 100 кг-аас дээш жинтэй эмэгтэйчүүд таван хүн тутмын нэг буюу 22%-ийг эзэлж байв. Кесар мэс заслын дараа халдварлагдсан шархтай эмэгтэйчүүдийн хоёр хүн тутмын нэг нь тамхи татдаг (49%), мэс заслын өмнө 3-5 хоногт усанд ороогүй (42%) өгүүлэмжтэй байв. Мэс заслын төрлийг харьцуулан судлахад яаралтай мэс засал 75,5%, төрөх өрөөнөөс төрөх хүчний үйл ажиллагаа алдагдсан, төрөлт сэдээлт үр дүнгүй, ургийн дистресс хамшинж үүссэний улмаас мэс засалд орсон 73%-ийг эзэлж байв. Кесар мэс заслаар төрсөн эмэгтэйчүүдийн 56% нь харьяа мэс заслын төвөөр 3-5 удаа боолт хийлгэсэн байна. Халдварлагдсан шархыг эмнэл зүйн шинж тэмдэгээр үнэлэхэд мэс заслын дараах өнгөц шархны халдвар 67 %, гүний шархны халдвар 33%, мэс заслын урсгуур гуурстай 33%-ийг эзэлсэн байна. Халдварлагдсан шарханд үрэвсэлийн шингэн хуримтлагдсан (27%), халуурсан (20%), шарх өвдөж эмзэглэлтэй болсон (16%), улайж халуу оргисон (18%) гэсэн зовиурууд давамгайлан илэрсэн байв.

Кесар хагалгааны дараах халдварлагдсан шархтай 45 эхийн мэс заслын шархнаас эмгэг төрөгч илрүүлэх арчдасын шинжилгээ авахад 11,1%-д эмгэг төрөгч илэрсэн, илрээгүй 15,5 % байсан. Харин нийт эмэгтэйчүүдийн 73,3 %-д бактериологийн шинжилгээ хийх шаардлагагүй гэж үзсэн байна. Кесар хагалгааны дараа мэс заслын шархны халдвар үүсэхэд эмнэлгээс нөлөөлөх зүйл байгаа эсэхийг судлахад НХАГ-т кесар мэс заслаар төрсөн эмэгтэйчүүдэд хагалгааны өмнөх антибиотик эмчилгээний урьдчилан сэргийлэлт 100% хийгдсэн, мэс заслын багийнхан эрүүл мэндийн үзлэгт жилд 1-2 удаа хамруулж, эрүүлжүүлдэг, мэс заслын хаалга чиптэй, мэс заслын тасгийн урсгал хөдөлгөөнийг тогтмол хянадаг. Мэс заслын хэсгийн цэвэрлэгээ ариутгал 100% хийгдэж, мэс заслын дараах шархны тандалт нь тушаалын дагуу 100%, агаарын арчдас шинжилгээнд гадаад дотоодын хяналтыг улирал бүр хийж, үр дүнг тооцсон. Эрүүл мэндийн сайдын 177 тоот тушаалын хэрэгжилт 99%, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг 45 эхэд 405 минут явуулсан. Сургалтын өмнөх сорил 47,6%-тай сургалтын дараа 83%-тай байсан. Халдварлагдсан шархтай 45 эхчүүдийн нийт ор хоног 32, боолт давхардсан тоогоор 1554 удаа, шарлага 796 удаа /199 цаг/, нийт хэрэглэсэн эмийн зардалд 24,473946 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хэлцэмж: P. G. Beattie болон бусад нарын 1992 онд хийгдсэн Risk Factors for Wound Infection Following Caesarean Section нэртэй судалгаанд эхчүүдийн жин мэс заслын дараах халдвар авах эрсдэлт хүчин зүйл болно хэмээн судлагдсан байна.

Veeravagu, Anand нарын 2019 оны судалгаанд Risk Factors for Postoperative Spinal Wound Infections After Spinal Decompression and Fusion Surgeries нэртэй судалгаанд жирэмсний чихрийн шижин өвчин (харьцааны харьцаа [OR] = 1.50), тамхи татдаг (OR = 1.19) нь илүүтэй нөлөөтэй байна.

Бидний судалгаагаар кесар хагалгааны дараа халдварлагдсан шарханд нөлөөлөх зарим хүчин зүйлсийг судлахад эхчүүдийн биеийн жингий илүүдэл 40%, тамхи таталт 38%, яаралтай хагалгаа 75,5% тус тус халдвар үүсэхэд нөлөөлсөн байна.

Дүгнэлт:

1. НХАГ-т 2018-2019 он, 2020 оны хагас жилийн байдлаар нийт 1823 эх кесар мэс засал хийлгэснээс халдварлагдсан шархтай 45 эх /2,46%/ мэс заслын дараах тусламж үйлчилгээ авсан байна. Эхийн талаас биеийн жингийн илүүдэл, тамхи татах, амьдрах орчин нөхцөл, яаралтай мэс заслын өмнөх бэлтгэл хангалт дутмаг, анх удаа мэс заслаар төрж байгаа эхчүүдийн эрүүл мэндийн боловсрол

хангалтгүй нь шархны халдвар үүсэхэд нөлөөлсөн байх боломжтой юм.

2. Эрүүл мэндийн байгууллагын зүгээс нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл бага, эерэг дүнтэй байна. Кесар хагалгааны дараах шархны халдвар эмчлэхэд ор хоног 32, эмчилгээний зардалд 24,473946 төгрөг зарцуулж байгаа нь эмч, сувилагчдын ажлын ачаалал нэмэгдэж, байгууллагын эмийн зардалд нөлөөлж байна.

Ном зүй:

1. *Hansa DharIbrahim Hilal Al BusaidiIbrahim Hilal Al Busaidi Bhawna Rathi Show Hamdi ALAOUI IlhamHamdi ALAOUI Ilham. A Study of Post-Caesarean Section Wound Infections in a Regional Referral Hospital, Oman, Sultan Qaboos University medical journal 14(2):e211-e217 Follow journal. 2014*
2. *Zuarez-Easton S, Zafran N, Garmi G, Salim R, Postcesarean wound infection: prevalence, impact, prevention, and management challenges. Dovepress.17 February 2017 Volume 2017:9 Pages 81—88*
3. *Charoenboon C, Srisupundit K, Tongsong T. Rise in cesarean section rate over a 20-year period in a public sector hospital in northern Thailand. Arch Gynecol Obstet. 2013;287(1):47–52.*
4. *Miller ES, Hahn K, Grobman WA. Consequences of a primary elective cesarean delivery across the reproductive life. Obstet Gynecol. 2013;121(4):789–797.*
5. *Molina G, Weiser TG, Lipsitz SR, et al. Relationship between cesarean delivery rate and maternal and neonatal mortality. JAMA. 2015;314(21):2263–2270.*
6. *Olsen MA, Butler AM, Willers DM, Devkota P, Gross GA, Fraser VJ. Risk factors for surgical site infection after low transverse cesarean section. Infect Control Hosp Epidemiol. 2008;29(6):477–484; discussion 485–486.*
7. *Schneid-Kofman N, Sheiner E, Levy A, Holcberg G. Risk factors for wound infection following cesarean deliveries. Int J Gynecol Obstet. 2005;90(1):10–15.*
8. *Opøien HK, Valbø A, Grinde-Andersen A, Walberg M. Post-cesarean surgical site infections according to CDC standards: rates and risk factors. A prospective cohort study. Acta Obstet Gynecol Scand. 2007;86(9):1097–1102.*
9. *ЭМС-ын А/539 тоот тушаал 2019-11-29*
10. *Мэс заслын үеийн сувилахуйн тусламж үйлчилгээний цогц шийдэл 2017. ШУГТЭ, ЭМЯ*

A STUDY OF SOME FACTORS POST CESAREAN SECTION WOUND INFECTION

B.Tuul[1], Ch.Tsagaankhuu[1], B.Tuya[1], V.Tumenjargal[1], S.Davaasuren[1], O.Baatarkhuu[2], B.Jargalsaikhan[2]*

[*]Corresponding author's email address: jargalsaikhan.b@mnums.edu.mn
[1]Khuree Maternity Hospital,
[2]School of Medicine, Mongolian National University of Medical Sciences

Background: The incidence of cesarean deliveries, both repeat and primary, has risen dramatically over the last few decades, with an estimated global number of 29.7 million cesarean deliveries in 2015. As a surgical procedure, cesarean delivery may be accompanied by a number of complications, surgical site infection (SSI) being one of them. The rate of SSI ranges from 3% to 15% worldwide. The variation in incidence may reflect differences in population characteristics and risk factors, perioperative practices, and the duration from the procedure until ascertainment. The risk for developing SSI has significantly decreased in the last three decades, mainly owing to improvements in hygiene conditions, antibiotic prophylaxis, sterile procedures, and other practices.

Aim: To study the factors that affect the wound infection of mothers who underwent emergency and planned surgeries at the "Khuree" maternity hospital in Ulaanbaatar, to determine how it affects the workload and drug costs, and to find ways to prevent and reduce the infection.

Objectives: 1. To study the factors influencing the infected wounds of mothers who underwent emergency and planned surgeries in the first half of 2018, 2019 and 2020 at the "Khuree" maternity hospital in the capital city.
2. The purpose of the study was to study the impact of the readmission of infected mothers on the workload of the organization and the medical staff and to determine further action.

Conclusion: 1. As of the first half of 2018, 2019 and 2020, a total of 1823 mothers underwent surgery and 45 mothers with infected wounds (2.46%) received postoperative care. Maternal overweight, smoking, living conditions, lack of preoperative preparation, and poor health education for mothers were all likely to be factors in wound infection.
2. According to the survey, the risk factors for health care organizations are low and positive. Spending 32 beds and 24,473,946 MNT on medical expenses increases the workload of doctors and nurses and affects the organization's drug costs.